



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/212-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: <a href="mailto:infoauditselenge@gmail.com">infoauditselenge@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. Аудитын илрүүлэлт .....	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	18-19

### Товчилсон үгийн жагсаалт

<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БШУГ</b>	Боловсрол, шинжлэх ухааны газар
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>УИХ</b>	Улсын их хурал



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОНТУУЛ СУМЫН НЭГДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
З.ЭНХЦОЛМОН ТАНАА

2024. 02. 23 № СЭА-2024/212-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн барилгын гадна фасад, цонхонд хийгдсэн 106,049.0 мянган төгрөгийн их засварын ажлыг капиталжуулан бүртгэсэн байна.

Тус цэцэрлэгийн 60 жилийн ойг тохиолдуулан УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатын хандивласан 10,000.0 мянган төгрөгийн гадна талбайн тоглоом, хөгжмийн зэмсэг, иргэд, ажилчдын хандиваар 4,770.0 мянган төгрөгийн телевизор, принтер зэрэг хөрөнгүүдийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 4,067.1 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

## **Аудитын гол асуудал**

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 7 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>44,218,655.79</b>	<b>129,237,753.07</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>24,905,748.36</b>	<b>74,055,699.64</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>24,905,748.36</b>	<b>74,055,699.64</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>24,905,748.36</b>	<b>74,055,699.64</b>
31211	Төрийн сангийн харилцах	24,905,748.36	74,055,699.64
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>358,112.93</b>	<b>358,112.93</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>358,112.93</b>	<b>358,112.93</b>
33510	Байгууллагаас авах авлага	358,112.93	358,112.93
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>18,954,794.50</b>	<b>54,823,940.50</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>18,954,794.50</b>	<b>54,823,940.50</b>
35420	Аж ахуйн материал	15,674,758.50	16,479,758.50
35460	Хүнсний материал	1,783,836.00	1,784,082.00
35470	Бусад хангамжийн материал	1,496,200.00	36,560,100.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>221,005,564.46</b>	<b>325,513,314.41</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>221,005,564.46</b>	<b>325,513,314.41</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>206,907,564.38</b>	<b>311,665,314.29</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	229,385,105.00	334,037,899.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(39,015,846.55)	(46,949,710.40)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	21,290,276.00	22,168,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,003,702.76)	(14,586,681.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,243,987.88	17,638,663.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,420,372.27)	(12,656,400.10)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,141,933.40	12,062,733.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,713,116.32)	(2,048,889.60)
39217	Ном	1,999,300.00	1,999,300.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>14,098,000.08</b>	<b>13,848,000.12</b>
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(499,999.92)	(749,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,348,000.00	13,348,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>265,224,220.25</b>	<b>454,751,067.48</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>265,224,220.25</b>	<b>454,751,067.48</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>265,224,220.25</b>	<b>454,751,067.48</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	90,475,639.00	90,475,639.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	90,475,639.00	90,475,639.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(31,765,958.10)</b>	<b>157,760,889.13</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(296,973,568.42)	(31,765,958.10)
51220	Тайлант үеийн үр дүн	265,207,610.32	189,526,847.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	206,514,539.35	206,514,539.35
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>265,224,220.25</b>	<b>454,751,067.48</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>689,008,046.17</b>	<b>689,520,846.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>256,624,480.79</b>	<b>151,636,934.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>256,624,480.79</b>	<b>151,636,934.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	237,097,856.49	120,819,034.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	19,526,624.30	30,817,900.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>432,383,565.38</b>	<b>537,883,912.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>391,307,300.00</b>	<b>502,101,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	391,307,300.00	502,101,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>41,076,265.38</b>	<b>35,782,112.50</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,076,265.38	35,782,112.50
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>423,800,435.85</b>	<b>499,769,338.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>423,800,435.85</b>	<b>499,769,338.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>418,025,135.85</b>	<b>497,125,738.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>293,810,780.00</b>	<b>352,304,404.00</b>
210101	Үндсэн цалин	219,599,636.00	250,628,177.00
210102	Нэмэгдэл	66,043,926.00	85,559,658.00
210104	Урамшуулал	8,167,218.00	16,116,569.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,300,868.64</b>	<b>44,036,108.72</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,425,045.93	30,071,177.30
210202	Тэтгэмжийн даатгал	3,836,457.03	3,494,335.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,410,490.87	2,795,539.55
210204	Ажилгүйдлийн даатгал	602,597.69	686,166.12
210205	Эрүүл мэндийн даатгал	6,026,277.12	6,988,890.09
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>26,106,265.38</b>	<b>33,315,112.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,616,993.38	5,267,678.50
210302	Түлш, халаалт	21,235,272.00	26,535,434.00
210303	Цэвэр, бохир ус	1,254,000.00	1,512,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,273,781.80</b>	-
210401	Бичиг хэрэг	653,440.80	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,620,341.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>30,148,898.00</b>	<b>38,460,171.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	87,680.00	-
210502	Хоол, хүнс	29,941,218.00	38,460,171.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	120,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>2,467,000.00</b>
210604	Урсгал засвар	-	2,467,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>785,100.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	785,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>28,384,542.03</b>	<b>25,757,842.65</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,066,450.00	7,251,019.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,675,800.00	2,420,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,642,292.03	16,086,623.65
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,775,300.00</b>	<b>2,643,600.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,775,300.00</b>	<b>2,643,600.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,775,300.00	2,643,600.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>265,207,610.32</b>	<b>189,751,507.63</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>224,660.40</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	224,660.40
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>265,207,610.32</b>	<b>189,526,847.23</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	432,383,565.38	537,883,912.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	432,383,565.38	537,883,912.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	391,307,300.00	502,101,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	391,307,300.00	502,101,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	41,076,265.38	35,782,112.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,076,265.38	35,782,112.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	406,927,817.02	488,733,961.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	406,927,817.02	488,733,961.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	401,152,517.02	486,090,361.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,789,093.28	352,304,404.00
210101	Үндсэн цалин	219,523,177.28	250,628,177.00
210102	Нэмэгдэл	66,098,698.00	85,559,658.00
210104	Урамшуулал	8,167,218.00	16,116,569.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,664,058.36	44,036,108.72
210201	Тэтгэврийн даатгал	25,314,285.65	30,071,177.30
210202	Тэтгэмжийн даатгал	3,310,407.03	3,494,335.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,410,490.87	2,795,539.55
210204	Ажилгүйдлийн даатгал	602,597.69	686,166.12
210205	Эрүүл мэндийн даатгал	6,026,277.12	6,988,890.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,106,265.38	33,315,112.50
210301	Гэрэл, цахилгаан	3,616,993.38	5,267,678.50
210302	Түлш, халаалт	21,235,272.00	26,535,434.00
210303	Цэвэр, бохир ус	1,254,000.00	1,512,000.00
2105	Нормативт зардал	27,460,070.00	38,460,417.00
210502	Хоол, хүнс	27,460,070.00	38,460,417.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,467,000.00
210604	Урсгал засвар	-	2,467,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	528,000.00	785,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	528,000.00	785,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,605,030.00	14,722,219.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,435,030.00	12,302,019.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,170,000.00	2,420,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,775,300.00	2,643,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,775,300.00	2,643,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,775,300.00	2,643,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	25,455,748.36	49,149,951.28
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	550,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	550,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	550,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	550,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(550,000.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	24,905,748.36	49,149,951.28
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	24,905,748.36
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,905,748.36	74,055,699.64

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	90,475,639.00	206,514,539.35	(296,973,568.42)	16,609.93
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	(296,973,568.42)	16,609.93
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	265,207,610.32	265,207,610.32
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	(31,765,958.10)	265,224,220.25
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	(31,765,958.10)	265,224,220.25
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	(31,765,958.10)	265,224,220.25
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	189,526,847.23	189,526,847.23
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	157,760,889.13	454,751,067.48

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>572,582,800.00</b>	<b>488,733,961.22</b>	<b>83,848,838.78</b>	<b>85.4</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>572,582,800.00</b>	<b>488,733,961.22</b>	<b>83,848,838.78</b>	<b>85.4</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>569,939,200.00</b>	<b>486,090,361.22</b>	<b>83,848,838.78</b>	<b>85.3</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>402,021,100.00</b>	<b>352,304,404.00</b>	<b>49,716,696.00</b>	<b>87.6</b>
210101	Үндсэн цалин	273,243,500.00	250,628,177.00	22,615,323.00	91.7
210102	Нэмэгдэл	113,986,200.00	85,559,658.00	28,426,542.00	75.1
210104	Урамшуулал	14,791,400.00	16,116,569.00	(1,325,169.00)	109.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>56,094,900.00</b>	<b>44,036,108.72</b>	<b>12,058,791.28</b>	<b>78.5</b>
210201	Тэтгэврийн даатгал	38,144,400.00	30,071,177.30	8,073,222.70	78.8
210202	Тэтгэмжийн даатгал	4,487,700.00	3,494,335.66	993,364.34	77.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,590,300.00	2,795,539.55	794,760.45	77.9
210204	Ажилгүйдлийн даатгал	897,500.00	686,166.12	211,333.88	76.5
210205	Эрүүл мэндийн даатгал	8,975,000.00	6,988,890.09	1,986,109.91	77.9
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>42,105,300.00</b>	<b>33,315,112.50</b>	<b>8,790,187.50</b>	<b>79.1</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,642,800.00	5,267,678.50	1,375,121.50	79.3
210302	Түлш, халаалт	33,715,400.00	26,535,434.00	7,179,966.00	78.7
210303	Цэвэр, бохир ус	1,747,100.00	1,512,000.00	235,100.00	86.5
2105	<b>Нормативт зардал</b>	<b>47,665,800.00</b>	<b>38,460,417.00</b>	<b>9,205,383.00</b>	<b>80.7</b>
210502	Хоол, хүнс	47,665,800.00	38,460,417.00	9,205,383.00	80.7
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,470,000.00</b>	<b>2,467,000.00</b>	<b>1,003,000.00</b>	<b>71.1</b>
210604	Урсгал засвар	3,470,000.00	2,467,000.00	1,003,000.00	71.1
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>813,400.00</b>	<b>785,100.00</b>	<b>28,300.00</b>	<b>96.5</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	813,400.00	785,100.00	28,300.00	96.5
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17,768,700.00</b>	<b>14,722,219.00</b>	<b>3,046,481.00</b>	<b>82.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,328,400.00	12,302,019.00	3,026,381.00	80.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,440,300.00	2,420,200.00	20,100.00	99.2
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,643,600.00</b>	<b>2,643,600.00</b>	-	<b>100.0</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,643,600.00</b>	<b>2,643,600.00</b>	-	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,643,600.00	2,643,600.00	-	100.0
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>572,582,800.00</b>	<b>537,883,912.50</b>	<b>34,698,887.50</b>	<b>93.9</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>502,101,800.00</b>	<b>502,101,800.00</b>	-	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	502,101,800.00	502,101,800.00	-	100.0
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>45,575,300.00</b>	<b>35,782,112.50</b>	<b>9,793,187.50</b>	<b>78.5</b>
320001	Орон нутгийн төсвөөс	45,575,300.00	35,782,112.50	9,793,187.50	78.5
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>24,905,700.00</b>	-	<b>24,905,700.00</b>	-
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	24,905,700.00	-	24,905,700.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	24,905,748.36	(24,905,748.36)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	74,055,699.64	(74,055,699.64)	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэг нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан цэцэрлэгийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эцэг эх асран хамгаалагч нарт цэцэрлэгийн үйл ажиллагааг танилцуулах, оролцоог нэмэгдүүлэх,
- Бага насны хүүхдийг амьдралын арга барилд сургах, дадал хэвшилд сургах,
- Номын сангийн үйлчилгээг, сургах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нээлттэй байдлаар хангах,
- Хүүхэд бүрийн онцлог ялгаатай байдлыг илрүүлэх, тэгш боловсролыг эзэмшүүлэх, сурлагын хоцрогдлыг арилгах, сурлагын ахиц гаргах.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд шинэчлэн батлагдсан,
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх", 2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 189,526.8 мянган төгрөгөөр буюу 71.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	24,905.7	74,055.7	49,150.0
Авлага	358.1	358.1	-
Бараа материал	18,954.8	54,823.9	35,869.1
Үндсэн хөрөнгө	221,005.6	325,513.3	104,507.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>265,224.2</b>	<b>454,751.0</b>	<b>189,526.8</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	265,224.2	454,751.0	189,526.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>265,224.2</b>	<b>454,751.0</b>	<b>189,526.8</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 74,055.7 мянган төгрөг болж 49,150.0 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
2. Бараа материалын дансны үлдэгдэл 54,823.9 мянган төгрөг болж 35,869.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 51,804.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, цэцэрлэгийн 60 жилийн ойн хандиваар иргэд, ажилчдаас 30,817.9 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд үйл ажиллагаанд 46,752.9 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас,
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 325,513.3 мянган төгрөг болж 104,507.7 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн барилгын гадна фасад, цонхонд хийгдсэн 106,049.0 мянган төгрөгийн их засварын ажлыг капиталжуулан бүртгэж, цэцэрлэгийн 60 жилийн ойгоор УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатын хандивласан 10,000.0 мянган төгрөгийн гадна талбайн тоглоом, хөгжмийн зэмсэг, иргэд, ажилчдын хандиваар 4,770.0 мянган төгрөгийн телевизор, принтер зэрэг хөрөнгүүдийг үнэ төлбөргүйгээр хүүлээн авч, сумын ИТХ-ын 2023 оны 12 сарын 18-ны өдрийн 83 дугаар тогтоолын дагуу 77 нэр төрлийн 11,972.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталснаас тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт

санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 629,900.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 43,892.5 мянган төгрөг нийт 670,792.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 297,752.0 мянган төгрөгөөр бууруулж 329,148.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 43,892.5 мянган төгрөгөөр, нийт 373,040.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур улсын төсвийн санхүүжилтийг 197,859.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 527,007.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 1,682.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 45,575.3 мянган төгрөгөөр нийт 572,582.8 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 527,007.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,575.3 мянган төгрөг, нийт 572,582.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 488,733.9 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвийн төсөвт 9,793.2 мянган төгрөгийг төвлөрүүлэн, 74,055.7 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 488,734.0 мянган төгрөг буюу 85.4 хувьтай байгаа нь эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 650.2 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 8,581.7 мянган төгрөгөөр, боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 880.1 мянган төгрөгөөр, нүүдлийн бүлэгт хамруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 4,295.7 мянган төгрөгөөр, боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 48,426.3 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах хөтөлбөрийн зардлыг 11,221.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт /хувиар/
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>527,007.5</b>	<b>452,951.8</b>	<b>74,055.7</b>	<b>85.9</b>
81605 - Эрүүл мэндийг дэмжих	1,220.2	570.0	650.2	46.7
81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	47,042.1	38,460.4	8,581.7	81.8
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,822.5	2,822.5	-	100.0
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх	1,780.1	900.0	880.1	50.6
81832- Нүүдлийн бүлэгт хамруулах	4,295.7	-	4,295.7	-

81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	359,390.1	310,963.8	48,426.3	86.5
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	110,456.8	99,235.1	11,221.7	89.8
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>45,575.3</b>	<b>35,782.1</b>	<b>9,793.2</b>	<b>78.5</b>
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	45,575.3	35,782.1	9,793.2	78.5
<b>ДҮН</b>	<b>572,582.8</b>	<b>488,733.9</b>	<b>83,848.9</b>	<b>85.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ хүүхдийн хоолны 40,352.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн нягтлан бодогчийг зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулахгүй байх, хоол хүнсний худалдан авалтыг хууль, тогтоомжийн дагуу гүйцэтгэж байх болон

шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З. Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 423,800.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,357.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллийг байршуулахаас 153 мэдээлэл байршуулан тухай бүр мэдээлэх 4 мэдээллийг хугацаа хоцроож 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд: Хугацаа хоцроосон ь:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал - 1 удаа,
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл - Хөтөлбөр, зориулалт - 1 удаа,
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан – 1 удаа
- Дараа жилийн төсвийн төсөл – 1 удаа

Огт мэдээлээгүй:

- Санхүүгийн тайлан - 1 удаа
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө – 1 удаа

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Замбалзоог” ХХК, “Буянт өргөн туул” ХХК, “Соларрейн” ХХК-тай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна. Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 2: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу ил тод нээлттэй зохион байгуулж, гүйцэтгэх зөвлөмж өгөв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 23/51 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд

хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,285.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс төлбөрийн цахим баримтаар баталгаажуагүй 2,203.2 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж бүртгэсэн, төсөвт тусгагдаагүй зардал гаргаж илүү цагийн хөлсийг нэмэгдүүлэн олгосон 3,082.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	2,203.20	1	2,203.20	100.0
Зөвлөмж	1	3,082.7	1	3,082.7	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>5,285.90</b>	<b>2</b>	<b>5,285.90</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “ Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт **668.4** мянган төгрөгийн урамшууллыг нягтлан бодогч Г.Баттуулд давхардуулан олгосон байна.Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт **990.0** мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс 990.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, зэрэгцсэн хөдөлмөр эрхэлж буй ажиллаж буй нягтлан бодогчийн цалинтай холбоотой зөрчилд 1 зөвлөмжийг хүргүүлээ.

### 5.1 Төлбөрийн акт

1. Шалгуур үзүүлэлтийг харгалзан, үнэлэлгүйгээр 6 туслах багшид тус бүр 25.0 хувиар тооцон нийт 990.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь "Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно" "**цэцэрлэгийн түвшинд амжилт гаргасан 10%**" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт: Орхонтуул сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн орон тоонд нягтлан бодогчоор ажиллаж буй Г.Баттуулыг тус цэцэрлэгт зэрэгцсэн хөдөлмөрөөр нягтлан бодогчоор ажиллуулан, цалинжуулж / үндсэн цалингийн 60.0 хувиар тооцож / байгаа нь дараах хуулиудыг тус тус зөрчиж байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх " Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ" 37.1.17: "Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх",
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ", 38.1.6: "Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх", 38.1.7:"Хууль

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх...*”

- Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4 -т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина”, 84 дүгээр зүйлийн 84.4 дэх “Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна” зэрэг.

2.2 Өгсөн зөвлөмж: 2 байгууллагад зэрэгцээ хөдөлмөрөөр нягтлан бодогчийн албан тушаал эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоож, зайлшгүй тохиолдолд 1-ээс илүү зэрэгцээ хөдөлмөр эрхлүүлэхгүй байж, цалинг өдрийн 4 цагаар бодож, 50.0 хувиас хэтрүүлэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг илүү бодож олгосон	1	990.0	1	990.0								
Нягтлан бодогчийг зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсан	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>990.0</b>	<b>1</b>	<b>990.0</b>			<b>1</b>					

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим санд 4 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт мэдээлээгүй	1	-							1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>								<b>1</b>			
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1								1			
<b>Дүн</b>	<b>1</b>								<b>1</b>			
<b>Нийт дүн</b>	<b>2</b>								<b>2</b>			